

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	2-3

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсад олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр өгөөжтэй ашиглах боломжтой хиймэл дагуулын талаар судлан, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	2-3
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 08-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Номин;

Тасалсан: А.Ганбаатар, Т.Мөнхсайхан.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсад олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр өгөөжтэй ашиглах боломжтой хиймэл дагуулын талаар судлан, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар үг хэлэв.

Ж.Золжаргал: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 1

Бүгд: 7

85.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 07 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 25 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаан эхэлж байна. Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Хэлэлцэх асуудал Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Ингээд ирцээ танилцуулъя. Байнгын хорооны ирц 54,5 хувьтай болсон байна. Улсын Их Хурлын гишүүн Анар, Батшугар, Галбадрах, Золжаргал, Мөнхбат, Цэнгүүн гишүүд хуралд оролцож байна.

Хэлэлцэх асуудлаа та бүхэндээ танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр өгөөжтэй ашиглах боломжтой хиймэл дагуулын талаар судлан холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулттай гишүүн байна уу? Асуулттай гишүүн байхгүй байна. Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулахаас өмнө ажлын хэсэг байгуулах хэрэгцээ шаардлагын талаар нэмэлт мэдээлэл өгнө үү гэж Анар гишүүнээс хүсэж байна. Анар гишүүний микрофоныг нээж өгье.

Ч.Анар: Сайн байцгаана уу. Тэгэхээр өнөөдөр та бүхэн, бид бүхэн мэдэж байгаа. Олон улсын нөхцөл байдал өөрчлөгдөж байна, гадаад чиг хандлага, олон туйлт дэлхий ертөнц үүсэж байна. Тэгэхээр аюулгүй байдлаа хангахын үүднээс бидэнд үндэстний хиймэл дагуулын төсөл зайлшгүй хэрэгтэй байгаа. Тэгээд Засгийн газрын 14 мега төслийн нэг хүрээнд орсон. Гэхдээ бидний Их Хурлын гишүүдийн зүгээс, Байнгын хорооны зүгээс авч үзэж байгаа шүүмжлэл нь өөрөөр хэлбэл төсөвт өртөг өндөр байна, техник, эдийн засгийн шаардлага дутуу байна гэдэг шүүмжлэлийг тавьж, энэ дээр холбогдох яам, Засгийн газар ажиллаж байгаа.

Тэгэхээр өнөөдөр нөхцөл байдал жил жилээр биш, сар сараар өөрчлөгдөж байгаа энэ цаг үед Их Хурлын гишүүд өөрөө Засгийн газартайгаа бусад стратегийн ач холбогдол бүхий мега төслүүдийг хамтран ажиллаж явж байгаа тэр зарчмын дагуу бид Инновац, цахим бодлогын байнгын хорооноос энэ асуудал дээр техникийн дүгнэлт, нөхцөл байдлын анализыг хамтран зэрэгцээд хийж яваад, хэлэлцээртээ ороод, цаг хугацаагаа хэмнэх нь зүйтэй байна л гэж үзэж байгаа юм. Тийм учраас ажлын хэсэг байгуулах шаардлагатай юм болов уу гэсэн саналтай байна.

Ж.Золжаргал: Баярлалаа. Инновац, цахим бодлогын байнгын хорооны үйл ажиллагааны хариуцсан чиг үүргийн хүрээнд хиймэл дагуул, харилцаа холбоо, судалгааны хиймэл дагуул мэдээж хамрагдана. Тэгээд ажлын хэсэг яавал илүү үр ашигтай, өгөөжтэй, Монгол Улсад өгөөжтэй байх вэ гэдэг боломжийг судалж, шийдвэр санал боловсруулах байх. Энэ бол төслийг дэмжих юм уу, эс дэмжих тухай

асуудал огтоосоо биш гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Өөр асуулттай, санал хэлэх гишүүн байхгүй бол тогтоолын төслөө уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь заалтыг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос тогтоох нь: Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр өгөөжтэй ажиллах боломжтой хиймэл дагуулын талаар судлан холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Ч.Анар, ажлын хэсгийн гишүүд Ж.Золжаргал, Э.Батшугар, Б.Пунсалмаа, Ж.Баярмаа, Д.Пүрэвдаваа ийм 6 хүний бүрэлдэхүүнтэй.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтныг тухай бүр татан оролцуулах, ажиллуулахыг ажлын хэсэг Ч.Анарт зөвшөөрсүгэй.

3.Холбогдох санал, дүгнэлтээ гарган цаашид авах арга хэмжээний саналаа боловсруулж, танилцуулахыг Ажлын хэсэг Ч.Анарт даалгасугай. Ийм томъёоллоор. Байнгын хорооны тогтоолыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад оролцсон 6 гишүүд, 7 гишүүнээс 6 нь дэмжиж 85,7 хувиар санал дэмжигдлээ.

13.32 цаг

Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг, та орчих, орчих, ирцдээ орчих. Байнгын хорооны хуралд Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа, Улсын Их Хурлын гишүүн Ундрам ирцэд орсон байгаа. Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА